



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2022/1/СТА-ТЭЗ

Цахим хуудас: www.audit.mn

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 7054-3156

Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Утас: 7054-3179

Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Батсайхан

Утас: 7054-3179

Цахим хаяг: Batsaikhants@audit.gov.mn

Чойр хот

2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2 байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	15
3.5.1 Мөнгөн хөрөнгө	15
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	16
3.5.3 Авлага.....	16
3.5.4 Урьдчилгаа	19
3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт	19
3.5.6 Бараа материал	20
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	21
3.5.8 Өр төлбөр.....	22
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	25
3.5.10 Орлогын данс	25
3.5.11 Зардлын данс	26
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	27
3.7 Шилэн дансны мэдээлэл	30
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	30
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	31
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	31
4. Аудитын илрүүлэлт	32

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АЗДНС	Аймгийн Засаг даргын нөөц сан
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд найрамдах хятад улс
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БТСГ	Биеийн тамирын спортын газар
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГСА	Говьсүмбэр аймаг
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНТС	Орон нутгийн тусгай сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1. Аудитын гэрчилгээ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2022.04.20 № 58

танай _____ -ны № _____ -т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БӨГӨӨД
ЗАСАГ ДАРГА Г.БАТЗАМ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

008020206

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		9,477,098.8	14,782,119.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	3,054,646.7	7,585,575.3
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	1,914,429.2	1,943,807.1
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	129,875.3	37,785.3
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	4,211,382.3	5,003,879.0
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	66,563.2	88,833.8
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	100,202.2	122,238.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		43,463,571.3	49,388,939.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	43,463,571.3	49,388,939.1
39200	Биет хөрөнгө		36,829,264.4	42,598,425.0
39300	Биет бус хөрөнгө	13	6,634,306.9	6,790,514.1
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		52,940,670.2	64,171,058.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		6,317,980.8	14,438,661.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	1,412,681.2	2,395,671.9
41300	Өглөг	17а, 17б	1,412,681.2	2,395,671.9
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		4,905,299.6	12,042,989.9
42100	Урт хугацаат үнэт цаас	19	0.0	0.0
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	4,905,299.6	12,042,989.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		46,622,689.3	49,732,396.6
51	Засгийн газрын хувь оролцоо		46,622,689.3	49,732,396.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		26,348,162.0	26,343,617.0
51200	Хуримтлагдсан үр дүн		7,882,877.1	10,955,103.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		12,391,650.2	12,433,676.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		52,940,670.2	64,171,058.4

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		28,032,602.60	32,925,669.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО		5,754,787.80	8,789,885.70
110	Орлогын албан татвар		4,224,195.80	5,483,444.20
1100	Хувь хүний орлогын албан татвар		4,419,617.80	5,657,849.30
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-195,422.00	-174,405.10
113	Хөрөнгийн албан татвар		492,174.00	736,868.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж		1,038,418.00	2,569,573.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	16,937,623.00	18,064,367.40
120	Нийтлэг татварын бус орлого		4,442,927.70	5,853,731.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		12,494,695.30	12,210,636.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		5,340,191.80	6,071,416.70
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	23,137,406.00	25,418,901.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ		23,137,406.00	25,217,448.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		22,000,793.00	24,505,055.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		10,029,948.00	10,598,175.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,232,473.70	1,426,478.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,392,344.10	1,468,457.80
2104	Хангамж, бараа материалын зардал		3,745,913.10	2,598,388.60
2105	Нормативт зардал		742,632.20	1,304,621.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		103,100.70	162,049.90
2107	Томилолт, зочны зардал		56,850.50	62,211.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,031,500.90	2,616,092.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,666,029.80	4,268,580.80
212	ТАТААС		163,073.10	152,983.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		973,539.90	559,409.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0	201,453.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		4,895,196.60	7,506,768.10
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0	2,503.00

Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		4,665,100.80	4,278,825.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		230,095.80	3,230,445.20

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	51,179,294.20	32,659,391.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО	5,754,787.80	8,789,885.70
110	Орлогын албан татвар	4,224,195.80	5,483,444.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	4,419,617.80	5,657,849.30
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-195,422.00	-174,405.10
113	Хөрөнгийн албан татвар	492,174.00	736,868.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,038,418.00	2,569,573.30
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	204,079.70	420,621.10
1181	Газрын төлбөр	465,272.60	1,460,983.90
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	369,065.70	687,968.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,192,474.00	18,360,155.20
120	Нийтлэг татварын бус орлого	4,697,778.70	6,149,518.80
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	12,494,695.30	12,210,636.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,232,032.40	5,509,350.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,450,933.10	22,638,333.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,450,933.10	22,638,333.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,435,853.70	21,854,281.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,575,625.00	11,521,057.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,414,344.90	1,727,163.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,652,290.60	1,765,240.70
2104	Хангамж, бараа материалын зардал	1,576,684.50	1,495,295.40
2105	Нормативт зардал	624,647.10	412,434.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	187,645.80	264,543.80
2107	Томилолт, зочны зардал	57,116.70	65,476.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,736,493.90	2,024,298.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,611,005.20	2,578,771.40
212	ТАТААС	163,073.10	152,983.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,852,006.40	631,067.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,728,361.00	10,021,058.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,016,307.40	5,413,859.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,016,307.40	5,413,859.40
2200	Дотоод эх үүсвэрээр	7,016,307.40	5,413,859.40
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,016,307.40	-5,413,859.40
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-91,298.00	-76,270.00

Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	91,298.00	76,270.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-1,379,244.40	4,530,928.60
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,433,891.00	3,054,646.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,054,646.70	7,585,575.30

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,901,607.10	45,901,607.10
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	11,816.40	11,816.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	45,913,423.50	45,913,423.50
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	437,207.80	437,207.80
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	41,962.20	41,962.20
6	Тайлант үеийн үр дүн	230,095.80	230,095.80
7	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	46,622,689.30	46,622,689.30
8	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	46,622,689.30	46,622,689.30
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-158,218.90	-158,218.90
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	46,464,470.40	46,464,470.40
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	38,026.00	38,026.00
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-2,520.00	-2,520.00
13	Өмчид гарсан өөрчилөлт	1,975.00	1,975.00
14	Тайлант үеийн үр дүн	3,230,445.20	3,230,445.20
15	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	49,732,396.60	49,732,396.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21.274.569.4	19,377,190.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,414,033.3	16,872,252.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,800,294.3	16,274,244.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,188,013.4	10,044,080.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,329,683.8	1,280,213.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,499,396.6	1,458,559.1
2104	Хангамж, бараа материалын зардал	292,820.9	283,428.4
2105	Нормативт зардал	223,041.3	206,961.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	365,141.4	362,461.7
2107	Томилолт, зочны зардал	67,910.2	56,285.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	556,775.8	541,911.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,277,510.9	2,040,344.5
212	ТАТААС	154,601.2	152,983.7
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	2,500.0	882.5
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	152,101.2	152,101.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	459,137.8	445,023.5
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	102,078.5	102,048.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	357,059.3	342,975.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,501,440.7	2,428,668.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	359,095.4	76,270.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,274,569.4	19,647,472.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,597,438.5	10,571,774.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,807,018.5	8,589,822.6
33	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	47,126.5	21,613.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	822,985.9	464,262.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		589,822.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		860,104.1
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	6,597	6,972
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	46	46
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	728	740
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	5,095	5,446

630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	3,445	3,695
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	1,650	1,751
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	728	740

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Тайлан оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,265,182.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,133,479.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	946,162.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	64,349.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,736.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,004.9
2103	Хангамж, бараа материалын зардал	84,996.9
2105	Нормативт зардал	107,811.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	85,344.3
2107	Томилолт, зочны зардал	6,524.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	232,872.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	336,521.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	187,316.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	114,175.1
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	73,141.4
22	Хөрөнгийн зардал	131,703.7
2200	Дотоод эх үүсвэрээр	131,703.7
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,265,996.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,265,996.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	813.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	813.6

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Г.Батзам танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн Төсвийн ерөнхийлөн захирагчид Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий дотоод хяналтын нэгжийг үр дүнтэй ажиллуулах, зөрчлийг бууруулах ажлыг зохион байгуулах зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 04 дүгээр сарын 06-наас 2022 оны 04 дүгээр сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсайхан гүйцэтгэв.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/430 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Аймгийн ТЕЗ нь “аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, эрсдэлийн удирдлагаар хангаж, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх” эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант онд хууль тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хууль тогтоомж зөрчигдөх зэрэг үр дагавартай байна.

Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 2021 онд санхүүгийн үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль болон Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого заавар, журмыг баримтлан ажилласан байна. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д заасны дагуу “ТЕЗ нар өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1-д зааснаар “ТЕЗ бүр дотоод аудитын алба байгуулж ажиллах” тухай хуулийн заалтуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 18 хяналт шалгалт хийхээс төлөвлөгөөт 11, төлөвлөгөөт бус 7, нийт 18 хяналт шалгалтыг хийсэн байна.

Тайлант хугацаанд 18 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар 726.1 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс нөхөн төлбөрийн 28.5 сая төгрөгийн актыг орон нутгийн орлого болгуулахаар, 31.7 сая төгрөгийн актыг холбогдох хүнд нь буцаан олгуулахаар акт тогтоосон байна. Дээрх хяналт шалгалтын дүнг аймгийн Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлсэн ба актын барагдуулалт 76.1 хувьтай байна.

Тухайн тайлант хугацаанд нийт 234.7 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хяналт шалгалт: Тус байгууллагаас Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд байнгын хяналт тавьж ажиллажээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор Сангийн яамнаас нэгдсэн хяналт шалгалт хийснээс гадна аймгийн төсвийн болон ОНӨҮГ, сан, орон нутгаас татаас авч буй хувийн цэцэрлэгүүдийг хамруулан нийт 77 байгууллагын шилэн дансны цахим хуудсанд хяналт шалгалтыг сар бүр тогтмол хийсэн байна.

Тайлант хугацаанд нийт 27 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг нэг бүрчлэн хянан шалгасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн хэрэгжилт эхний 11 сарын байдлаар 96.7 хувьтай байна. 2021 оны эхний 3 дугаар улирлын байдлаар шилэн дансны тайлан 100 хувь илгээгдсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн

тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн зардлын 23,137.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 231.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 185.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,054.6 сая, эцсийн үлдэгдэл 7,585.6 сая төгрөг болж, 4,531.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.9	0.9	0.0
Банканд байгаа бэлэн мөнгө	3,053.7	7,584.7	4,531.0
Дүн	3,054.6	7,585.6	4,531.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	683.7	960.5	276.8
Төсөл/ сан	606.5	1,905.8	1,299.3
Төрийн сан	1,570.7	4,597.8	3,027.1
ТӨҮГ болон ОНӨҮГ	193.8	121.5	-72.3
Дүн	3,054.6	7,585.6	4,531.0

Эх сурвалж Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Касст байгаа бэлэн мөнгөний 0.9 сая төгрөгийн үлдэгдлээс 0.5 сая төгрөг нь “Ус-Ду” ОНӨААТҮГ, 0.3 сая төгрөг нь “Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын кассын үлдэгдэл байна.

Банкинд байршиж буй нийт 7,585.6 сая төгрөгийн 7,464.1 сая төгрөг нь төрийн санд, 120.6 сая төгрөг нь арилжааны банкинд байршиж байна. Үүнээс: 960.5 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 120.6 сая төгрөг нь төрийн болон ОНӨААТҮГ-ын, 4,597.8 сая төгрөг нь төрийн сангийн, 1,905.8 сая төгрөг нь төсөл, сангийн үлдэгдэл байна.

- Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 960.5 сая төгрөгийг байгууллагаар нь задалбал: АОНХС-гийн дансанд 193.9 сая, Шивээговь сумын ОНХС-гийн дансанд 31.2 сая, СХС-гийн дансанд 61.0 сая, Баянтал сумын ОНХС-гийн дансанд 5.8 сая, СХС-гийн дансанд 61.0 сая, Сүмбэр сумын ОНХС-гийн дансанд 142.6 сая, СХС-гийн дансанд 362.7 сая, Сумдын эрүүл мэндийн төвийн дансанд 2.8 сая, төсвийн байгууллагуудын ахмадын сангийн дансанд 99.5 сая төгрөг тус тус байна.
- Төсөл, сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,905.8 сая төгрөг /аймгийн хөрөнгө оруулалтын барьцаа дансанд 1,816.3 сая, Шивээговь сумын

хөрөнгө оруулалтын барьцаа дансанд 7.9 сая, Сүмбэр сумын хөрөнгө оруулалтын барьцаа дансанд 41.6 сая, нэмэлт дансны үлдэгдэл 40.0 сая/

- Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4,597.8 сая төгрөг /Ерөнхий орлогын үлдэгдэл аймагт 4,152.3 сая, Сүмбэр суманд 368.8 сая, Шивээговь суманд 38.3 сая, Баянтал суманд 38.4 сая/
- ОНӨААТҮГ-ын арилжааны банкны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 121.5 сая төгрөг /“Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ 37.9 сая, “Ус-Ду” ОНӨААТҮГ 2.9 сая, “Илчлэг Шивээ” ОНӨААТҮГ 8.7 сая, “Талын-Илч” ОНӨААТҮГ 2.0 сая, Энхтусдэм ӨЭМТ 67.7 сая, Аймгийн ахмадын хороо 2.3 сая / тус тус байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,570.7 сая, эцсийн үлдэгдэл 4,597.8 сая төгрөг болж, 3,027.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа мөнгөн хөрөнгө			
Төгрөг			
Төрийн сан	1,570.7	4,597.8	3,027.1
Нийт дүн	1,570.7	4,597.8	3,027.1

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн эхний үлдэгдэл 1,570.7 сая төгрөг байснаас тайлант онд орон нутгийн төсвийн татварын орлого 8,789.9 сая төгрөг, татварын бус орлого 1,202.5 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 9,039.3 сая, ОНХНС-гийн санхүүжилт 1.558.1 сая, улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг 1,613.2 сая, орон нутгийн төсөвт байгууллагын төсвийн хэмнэлт 1,217.2 сая, аймаг, сумдын нэмэлт дансны үлдэгдэл 11.3 сая, сумдад олгосон санхүүгийн дэмжлэг 2,444.5 сая нийт 25,876.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, харьяа байгууллагуудын урсгал болон хөрөнгө оруулалтын санхүүжилтэд нийт 22,848.9 сая төгрөгийг зарцуулж, 4,597.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой материаллаг зөрчил илрээгүй.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат хөрөнгө оруулалт бүртгэгдээгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1,914.4 сая, эцсийн үлдэгдэл 1,943.8 сая төгрөг болж 29.4 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь тайлант онд Баянтал сумын СХС-гаас зээл олгосон, сумдын эрүүл мэндийн төвүүд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт дутуу авч авлага үүсгэсэн, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүйгээс тооцооллын алдаа гаргаж, ажиллагсадтай холбогдсон болон бусад авлага нэмэгдсэнтэй

холбоотой байна.

Хүснэгт №.3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	11.6	6.7	-4.9
Төлбөртэй үйлчилгээний авлага	48.7	512.9	464.2
Зээлийн хүүгийн авлага	43.1	33.3	-9.8
Дансны авлага /ТӨҮГ/	30.3	31.6	1.3
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	2.6	3.0	0.4
Байгууллагаас авах авлага	525.4	373.9	-151.5
Хувь хүнээс авах авлага	1,252.7	982.5	-270.1
Дүн	1,914.4	1,943.8	29.4
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			0.0
Төсөвт байгууллага	1,472.0	1,507.8	35.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	442.5	436.0	-6.4
Дүн	1,914.4	1,943.8	29.4

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдлийг нэр, төрлөөр нь задалж харуулбал:

1. Ажиллагсадтай холбогдсон авлага өмнөх оноос тайлант онд нийт дүнгээрээ 4.9 сая төгрөгөөр буурсан боловч 11 байгууллага 6.4 сая төгрөгийг барагдуулж, 3 байгууллага 1.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. /АИТХ-0.2 сая, "Илчлэг-Шивээ" ОНӨҮГ-0.3 сая, Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн 1.0 сая/
2. Төлбөртэй үйлчилгээний авлага өмнөх оноос нийт дүнгээрээ 464.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Ковид-18 цар тахлын эмчилгээний санхүүжилт дутуу авснаас 3 сумын ЭМТ 501.5 сая төгрөгийн авлага нэмэгдэж, Сүмбэр сумын СХС-гийн зээлийн алдангийн авлага 37.3 сая төгрөгөөр буурсан.
3. Зээлийн хүүгийн авлага өмнөх оноос нийт дүнгээрээ 9.8 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: Сүмбэр сумын СХС-гийн авлагыг 10.0 сая төгрөгөөр бууруулж, Шивээговь сумын СХС-ийн авлагыг 0.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн/
4. Дансны авлага /ТӨҮГ/ нь 31.6 сая /"Талын-Илч" ОНӨААТҮГ-ын халаалтын авлага бөгөөд тайлант онд 1.3 сая төгрөгөөр нэмэгдсэн/
5. Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/ нь 3.0 сая /"Талын-Илч" ОНӨААТҮГ-ын авлага бөгөөд тайланд онд 0.4 сая төгрөгөөр нэмэгдсэн /
6. Байгууллагаас авах авлага өмнөх оноос нийт дүнгээрээ 151.5 сая төгрөгөөр буурсан боловч байгууллага тус бүрээр нь харвал 4 байгууллага 34.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 8 байгууллага 186.1 сая төгрөгөөр бууруулсан байна.
7. Хувь хүнээс авах авлага өмнөх оноос нийт дүнгээрээ 270.1 сая төгрөгөөр буурсан боловч байгууллага тус бүрээр нь харвал 2 байгууллага 37.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 7 байгууллага 307.7 сая төгрөгөөр бууруулсан байна.

Хүснэгт №.4. Авлагыг аймаг, сумдаар нь харуулбал

/сая төгрөг/

Аймаг, сумдын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар	Нийт үлдэгдэлд эзлэх хувь
Аймаг	554.0	405.9	-148.1	-27	21
Сүмбэр сум	997.6	815.3	-182.3	-18	42
Баянтал сум	181.5	320.0	138.5	76	16
Шивээговь сум	181.3	402.6	221.3	122	21
НИЙТ ДҮН	1,914.4	1,943.8	29.4	2	100

Хүснэгтээс харахад: Өмнөх оноос Баянтал сумын авлага 76%, Шивээговь сумын авлага 122%-иар тус тус нэмэгдэж, аймгийн авлага 27%, Сүмбэр сумын авлага 18%-иар тус тус буурсан байна

Мөн нийт авлагын 21%-ийг аймаг, 42%-ийг Сүмбэр сум, 16%-ийг Баянтал сум, 21%-ийг Шивээговь сум тус тус эзэлж байна.

Энэ нь тайланд онд Ковид-18 цар тахлын эмчилгээний санхүүжилт дутуу авснаас Энхтусдэм ӨЭМТ 137.3 сая, Шивээговь сумын ЭМТ 230.5 сая, Баянтал сумын ЭМТ 133.7 сая төгрөгийн нийт 501.5 сая төгрөгийн авлага, Баянтал сумын СХС-гаас 75.6 сая төгрөгийн зээл олгосон зэрэг нь нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд 0-1 жил хүртэлх 1,464.2 сая, 1-2 жил хүртэлх 63.9 сая, 2-3 жил хүртэлх 12.0 сая, 3-4 жил хүртэлх 3.8 сая, 4-5 жил хүртэлх 22.4 сая, 5 жилээс дээш хугацаатай 377.5 сая төгрөгийн авлага тус тус байна.

Авлагын үлдэгдлийн 1,653.1 сая төгрөг буюу 85 хувийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

Авлагын данстай холбоотой материаллаг нийт 516.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч нийт 440.6 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 75.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө. Үүнд:

- “Ус-Ду” ОНӨААТҮГ нь санхүүгийн байдлын тайлан дахь авлагын дүнд тооцоо нийлж, баталгаажуулаагүй, төлбөр хийгдэх нь тодорхой бус тооцоо нийлж баталгаажуулаагүй 67.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, “Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ нь Төсөв байгууллагуудын гэрээний заалтыг зөрчин гэрээнд өөрчлөлт оруулалгүйгээр жилийн дундуур халаалт болон цэвэр бохир усны зардлын үйлчилгээний төлбөрийг нэмэгдүүлэн 14.4 сая, мөн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 220.8 сая /Ус-Ду ОНӨААТҮГ-208.6 сая, “Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ 12.6 сая/, төгрөгийн авлага тус тус бүртгэсэн, Энхтусдэм ӨЭМТ нь ЭМД-ын сангаас 137.2 сая төгрөгийг авах авлагыг татаас санхүүжилтийн авлагаар тайлагнасан зэрэг зөрчлүүдийг залруулсан
- “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ нь 10.8 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, “Тохижилт сүмбэр” ОНӨААТҮГ нь өмнөх онуудын үлдэгдэл ААНБ, айл өрхөөс авах 18.1 сая төгрөгийн хог хаягдлын авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулаагүй, Баянтал сумын ЗДТГ нь санхүүгийн тайланд тусгагдсан хугацаа хэтэрсэн 46.9 сая төгрөгийн авлага барагдуулаагүй зэрэгт тус тус албан шаардлага өгсөн.

7.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 129.8 сая, эцсийн үлдэгдэл 37.8 сая төгрөг болж 92.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0.7	1.9	1.2
Төсөвт байгууллага	108.1	15.0	-93.1
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1.0	1.0	0.0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	15.0	15.0	0.0
Цалингийн урьдчилгаа	5.0	4.9	-0.1
Дүн	129.8	37.8	-92.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	129.8	37.8	-92.0
Дүн	129.8	37.8	-92.0

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд өмнөх онд үүссэн 25.0 сая, 2021 онд үүссэн 12.8 сая, нийт 37.8 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. Үүнд: төсөвт байгууллагын урьдчилгааны үлдэгдэл 40%, үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа 40%, цалингийн урьдчилгаа 12%, бараа материал бэлтгэх болон урьдчилж гарсан зардал 8%-ийг тус тус эзэлж байна.

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдлийг задалж харуулбал:

Аймгийн ЗДТГ-ын төсөвт байгууллагын урьдчилгаа дансны үлдэгдэл 15.0 сая,

- Аймгийн ИТХ-ын урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 1.9 сая,
- Аймгийн авто замын сангийн бараа материал болон үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа 16.0 сая,
- Цалингийн урьдчилгаа дансны үлдэгдэл 4.9 сая төгрөг нь 4 байгууллагын цалингийн урьдчилгаа тусгагдсан байна. Тухайлбал: Баянтал сумын ЗДТГ-ын 0.2 сая, 4 дүгээр цэцэрлэгийн 0.2 сая, Эрүүл мэндийн төвийн 4.0 сая, Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэгийн 0.5 сая төгрөгийн үлдэгдлүүд байгаа бөгөөд эдгээр нь тооцооллын алдаа гаргаж, урьдчилгааг дутуу суутгаснаас үүссэн байна.

Аудитын илрүүлэлт:

Урьдчилгаа данстай холбоотой материаллаг зөрчил илрээгүй.

7.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт бүртгэлгүй байна.

7.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 4,211.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,003.9 сая төгрөг болж, 792.5 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд аймаг, сумдын ОНХС болон харьяа дээд байгууллагуудаас үнэ төлбөргүй бараа материал хүлээн авсантай холбоотой байна.

Хүснэгт №6. Бараа материалын үлдэгдэл			/сая төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	352.3	461.4	109.1
Бэлэн бүтээгдэхүүн	5.2	7.8	2.6
Хангамжийн материал	3,395.8	4,139.0	743.2
Мал амьтад	458.1	395.8	-62.3
Дүн	4,211.4	5,003.9	792.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	3,951.6	4,635.0	683.4
ТӨҮГ болон ОНӨҮГ	259.8	368.9	109.1
Дүн	4,211.4	5,003.9	792.5

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эхний үлдэгдэл 4,211.4 сая төгрөг байсан ба тайлант онд худалдан авсан 2,703.8 сая, хандиваар авсан 496.3 сая, шилжүүлж авсан 598.4 сая, үнэ төлбөргүй авсан бараа 1,204.8 сая, нийт 5,003.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 3,803.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 127.8 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, бусад 279.2 сая, нийт 4,210.8 сая төгрөгөөр хасагдаж, 5,003.9 сая төгрөгийн бараа материалыг үлдэгдлээр тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материалын данстай холбоотой материаллаг нийт 407.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 108.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 101.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 197.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд:

- Залруулсан алдаа 108.4 сая төгрөг бөгөөд бараа материалыг ангилал зөрүүтэй тайлагнасан 48.8 сая /Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ-21.8 сая, Сүмбэр сумын 2 дугаар сургууль 11.0 сая, 5 дугаар цэцэрлэг 16.0 сая/, "Илчлэг-Шивээ" ОНӨААТҮГ нь нярвын бараа материалын тайлангийн эхний үлэгдэл болон санхүүгийн тайлангийн бараа материалын эхний үлдэгдэл зөрүүтэй тайлагнасан 32.4 сая, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь судалгаа, шинжилгээний ажлын тайлан 27.2 сая төгрөгийг бичиг хэргийн материалын дансанд бүртгэж, тайланд онд зардлаар хааж данснаас хассан байна.
- Албан шаардлага 101.1 сая төгрөг. Үүнд: Шивээговь сумын ЭМТ нь 24.0 сая төгрөгийн эмнэлгийн хэрэгслийг бусад нөөцийн бараагаар бүртгэсэн, "Талын илч" ОНӨААТҮГ нь БНХАУ-ын Эрээн хотоос байгууллагад шаардлагатай бараа материал худалдан авсан боловч 26.0 сая төгрөгийн анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн, "Цөм сүргийн үржлийн төв" ОНӨҮГ нь төвийн захирлын тушаалаар 28.4 сая төгрөгийн хурганы арьс актлахдаа шатны баримтгүй, мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүй данснаас хассан, Баянтал сумын ЭМТ нь бараа материалын тайланг 20.0 сая төгрөгөөр зөрүүтэй бэлтгэж, байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр 2.7 сая төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан.

- Зөвлөмж 197.7 сая төгрөг. Үүнд: Аймгийн БТСГ нь бараа материалын дансны 14.0 сая төгрөгийн ажил гүйлгээг зөв ангилан бүртгэж тайлагнаагүй, Шивээговь сумын ЗДТГ нь урсгал засварын ажлын 183.7 сая төгрөгийг бараа материалаар бүртгэж тайлагнасан.

Нөөцийн барааны эхний үлдэгдэл 66.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 88.8 сая төгрөг болж, 22.3 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь аймгийн ОНХС-гаас өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 7 Нөөцийн бараа үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тэжээлийн нөөц	37.9	48.9	11.0
Бусад нөөц	28.6	39.9	11.3
Дүн	66.5	88.8	22.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	66.5	88.8	22.3
Дүн	66.5	88.8	22.3

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын нөөцийн барааны үлдэгдлийг байгууллагаар нь харуулбал:

- Баянтал сумын ЗДТГ-ын өвс тэжээл 13.7 сая,
- Сүмбэр сумын ЗДТГ-ын өвс тэжээл 35.1 сая,
- Шивээговь сумын ЗДТГ-ын өвс тэжээл 7.0 сая
- Шивээговь сумын Эрүүл мэндийн төвийн нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл 24.0 сая,
- Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн ном 9.0 сая төгрөг тус тус байна.

7.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 43,463.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 49,388.9 сая төгрөг болж, 5,925.3 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймаг сумдын ОНХС-гаас хөрөнгө хүлээн авсантай холбоотой байна.

Хүснэгт №. 8 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	21,682.5	24,516.7	2,834.2
Авто-тээврийн хэрэгсэл	1,461.6	1,606.4	144.8
Машин тоног төхөөрөмж(компьютер)	4,249.5	4,543.3	293.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	944.0	878.5	-65.5
Зам, гүүрийн байгууламж	2,618.6	5,568.1	2,949.5
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	86.5	87.4	0.9
Бусад үндсэн хөрөнгө	5,550.0	5,178.0	-372.0
Дуусаагүй барилга, байгууламж	40.7	15.0	-25.7
Биет бус хөрөнгө	6,634.3	6,790.5	156.2

Ном	195.9	204.9	9.0
Дүн	43,463.6	49,388.9	5,925.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	28,433.5	27,882.4	-551.1
ТӨҮГ болон ОНӨҮГ	15,030.1	21,506.6	6,476.5
Дүн	43,463.6	49,388.9	5,925.3

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаанд нийт 11,790.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн ба үүнээс худалдан авсан 354.1 сая, хандив тусламжаар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 133.0 сая, шилжүүлж авсан 5,020.8 сая, ОНӨҮГ-ын хөрөнгийн орлого 5,809.0 сая, дахин үнэлгээгээр 473.7 сая төгрөг тус тус нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд нийт 4,027.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдсан ба үүнээс худалдсан 6.0 сая, шилжүүлсэн 1,014.7 сая, акталсан 1,791.2 сая, дахин үнэлгээний хорогдол 536.3 сая, ОНӨҮГ-ын хөрөнгийн зарлага 679.0 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 15.0 сая төгрөг нь “Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын барилгын өргөтгөлийн зураг байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 1,147.9 сая төгрөгийн материаллаг алдаа, зөрчил илэрснээс нийт 718.7 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 429.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, албан шаардлага өглөө. Үүнд:

Залруулсан алдаа 718.7 сая төгрөг бөгөөд үндсэн хөрөнгийг ангилал зөрүүтэй бүртгэсэн 246.6 сая төгрөг /Сум дундын ойн анги ОНӨҮГ 18.1 сая, Сүмбэр сумын ТТЗ-91.7 сая, ЗДТГ-110.8 сая, Баянтал сумын 4 дүгээр сургууль 26.0 сая/, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг нь 472.1 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний дансны бичилтийг зөрүүтэй бүртгэсэн/

Албан шаардлага 429.2 сая төгрөг /”Талын илч” ОНӨААТҮГ нь ашиглалтын хугацаа дууссан 204.2 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлээгүй, Шивээговь сумын ОНХС-гийн хөрөнгөөр худалдан авсан 64.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, Сүмбэр сумын 5 дугаар сургууль нь 140.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг нэр, төрөл, тоо хэмжээгээр бүртгээгүй бөөн дүнгээр бүртгэсэн, Шивээговь сумын ИТХ нь 19.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ангилал зөрүүтэй бүртгэсэн/

7.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 6,318.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 14,438.7 сая төгрөг болж, 8,120.7 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын үлдэгдэл санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд өглөгөөр тусгасан, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүйгээс тооцооллын алдаа гаргасан зэргээс өглөг нэмэгдсэн байна.

Хүснэгт № 9 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	1,412.7	2,395.7	983.0
Ажилчидтай холбогдсон өглөг	1.9	22.5	20.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	9.7	19.2	9.4
Байгууллагад төлөх өглөг	1,380.9	2,221.1	840.2
Хувь хүмүүст төлөх өглөг	2.0	2.2	0.1
Татвар, НДШ-ийн өглөг	18.0	130.7	112.7
Урт хугацаат өр төлбөр дүн	4,905.3	12,043.0	7,137.7
Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	4,905.3	12,043.0	7,137.7
Нийт дүн	6,318.0	14,438.7	8,120.7
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	73.3	80.4	7.1
Төсөл, сан	595.1	1,880.9	1,285.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	5,649.6	12,477.3	6,827.7
ДҮН	6,318.0	14,438.7	8,120.7

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс харахад: Богино хугацаат өр төлбөр нийт 983.0 сая төгрөгөөр буюу 70%-иар, урт хугацаат өглөг 7,137.7 сая төгрөгөөр буюу 145%-иар тус тус өссөн байна.

Хүснэгт № 10 Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийг аймаг, сум тус бүрээр харуулбал:


/сая төгрөг /

Д/д	Сумдын нэр	Нийт өр төлбөр		Зөрүү	Нийт дүнд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
1	Сүмбэр сум	139.9	44.6	-95.3	1.9
2	Баянтал сум	13.7	10.0	-3.7	0.4
3	Шивээговь сум	14.1	35.7	21.6	1.5
4	Говьсүмбэр аймаг	1,245.0	2,305.4	1,060.4	96.2
	Дүн	1,412.7	2,395.7	983.0	100

Хүснэгтээс харахад: Тайлант оны өглөгийн үлдэгдэл өмнөх оноос нийт 983.0 сая төгрөгөөр өссөн бөгөөд аймаг 1,060.4 сая, Шивээговь сум 21.6 сая төгрөгөөр тус тус өсөж, Сүмбэр сумын өглөг 95.3 сая, Баянтал сум 3.7 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Аймгийн хөрөнгө оруулалтын барьцаа дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын үлдэгдэл санхүүжилтийг төвлөрүүлсэн, Шивээговь ЭМТ санхүүжилт дутуу авснаас ажилчдын цалин, НДШ-ийн өглөг үүсгэсэн зэрэг нь нөлөөлжээ.

ТЕЗ-ийн нийт өр төлбөрт эзэлж байгаа хувь хэмжээг аймаг, сумдаар нь диаграммаар харуулбал:



Диаграммаас харахад: Нийт өр төлбөрийн 1.9%-ийг Сүмбэр сум, 0.4 %-ийг Баянтал сум, 1.5%-ийг Шивээговь сум, 96.2%-ийг аймгийн төвийн байгууллагууд эзэлж байна.

Хүснэгт № 11 Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл байгууллагын төрлөөр: /сая төгрөг/

№	Байгууллагуудын төрөл	Эцсийн үлдэгдэл	Нийт дүнд эзлэх хувь
1	Орон нутгийн төсөвт байгууллага	18.3	1
2	Аймаг, сумдын хөрөнгө оруулалтын барьцаа	1,865.9	78
3	Тусгай сангийн өглөг	32.2	1
4	Тусгай шилжүүлгийн байгууллагууд	37.2	2
5	Аймаг, сумдын ОНХС	1.2	0
6	ОНӨААТҮГ	440.9	18
Дүн		2,395.7	100

Хүснэгтээс харахад: Нийт богино хугацаат өр төлбөрийн 18.0%-ийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, 78.0%-ийг аймаг, сумдын хөрөнгө оруулалтын барьцааны өглөг, 1.0%-ийг орон нутгийн төсөвт байгууллагууд, 1.0%-ийг тусгай сангийн өглөг, 2.0%-ийг тусгай шилжүүлгийн байгууллагууд тус тус эзэлж байна.

Өглөгийн үлдэгдлийг байгууллага тус бүрээр болон төрлөөр нь ангилбал дараах байдалтай байна. Үүнд:

- Орон нутгийн төсөвт байгууллагын өглөгийн үлдэгдэл нийт 18.3 сая төгрөг /Аймгийн ИТХ-ын 0.2 сая, АЗДТГ-ын 15.2 сая, Боржигин чуулгын 0.5 сая, Баянтал сумын ЗДТГ-1.3 сая, Сүмбэр сумын ЗДТГ-ын 0.4 сая, Шивээговь сумын ЗДТГ-ын 0.7 сая/
- Аймаг, сумдын барьцаа дансны хөрөнгө оруулалтын барьцааны өглөг нь 1,865.9 сая төгрөг /аймагт 1,816.4 сая, Шивээговь сумын 7.9 сая, Сүмбэр сумын 41.6 сая /
- Тусгай сангийн өглөг нь аймгийн Автозамын сангийн хөрөнгө оруулалтын ажлын өглөг 32.2 сая төгрөг.
- Тусгай шилжүүлгийн байгууллагын өглөгийн үлдэгдэл нийт 37.2 сая төгрөг бөгөөд Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн 1.1 сая, 5 дугаар сургуулийн 1.5 сая, Шивээговь сумын ЭМТ-ийн 27.0 сая, Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 3.8 сая, ЭМТ-ийн 3.8 сая төгрөг.
- Аймаг, сумдын ОНХС-гийн өглөгийн үлдэгдэл нь Баянтал сумын ОНХС-гийн 1.2 сая төгрөг.

- ОНӨААТҮГ-ын өглөгийн үлдэгдэл нийт 440.9 сая төгрөг бөгөөд аймгийн “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ-ын 6.6 сая, “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 216.1 сая, “Тохижилт-сүмбэр” ОНӨААТҮГ-ын 0.2 сая, “Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын 211.8 сая, “Талын-Илч” ОНӨААТҮГ-ын 6.2 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

Өглөгийн данстай холбоотой материаллаг зөрчил илрээгүй

7.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцооны дансны эхний үлдэгдэл 46,622.7 сая, эцсийн үлдэгдэл 49,732.4 сая төгрөг болж 3,109.7 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-
Засгийн газрын оруулсан капитал /ЗГТС/ ОНТС	25,124.2	25,119.6	-4.6
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	1,224.0	1,224.0	0.0
Хуримтлагдсан үр дүн	7,882.9	10,955.1	3,072.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	12,391.6	12,433.7	42.1
Дүн	46,622.7	49,732.4	3,109.7

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтэд харуулснаар дансдын үзүүлэлтээрх өөрчлөлтийн тайлбар дараах байдалтай байна. Үүнд:

1. Засгийн газрын оруулсан капитал дансны өөрчлөлт 4.6 сая төгрөг нь аймгийн Нийтийн номын сан 2.5 сая, “Ус-Ду” ОНӨААТҮГ-2.0 сая төгрөгийн бүртгэлтэй газрыг тус тус шилжүүлсэн байна.
2. Тайлант онд хуримтлагдсан үр дүн данс нийт 3,072.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс 3,230.4 сая төгрөг нь тайлант хугацааны үр дүн, -158.2 сая төгрөг нь 16 байгууллагын бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байна.
3. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 42.1 сая төгрөг нь 5 байгууллагын хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээр өөрчлөгдсөн байна.

7.5.10 Орлогын данс

Орлого, үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн үйл ажиллагааны орлогод нийт 424.0 сая, /сум хөгжүүлэх сангийн орлого 19.3 сая, “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ-ын өөрийн орлого 22.0 сая, ГХБХБГ-ын орлого 13.5 сая, ахмадын хорооны орлого 0.7 сая, аймгийн БТСГ-ын орлого 10.5 сая, Энхтусдэм ӨЭМТ-ийн орлого 358.0 сая/ туслах үйл ажиллагааны орлогод нийт 188.1 сая /сум хөгжүүлэх сангийн орлого 4.0 сая, авто замын сан болон АЗДТГ-ын өөрийн орлого 51.7 сая, ерхийн эрүүл мэндийн төвийн орлого 71.6 сая, ахмадын хорооны орлого 4.1 сая, байгууллагуудын ахмадын сангийн орлого 56.7 сая/ төгрөгийг тус тус тайлагнасан байна.

Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад үндсэн үйл ажиллагааны орлого 361.7 сая төгрөг буюу 78 хувиар, туслах үйл ажиллагааны орлого 214.9 сая төгрөгөөр буюу 68.5 хувиар тус тус өссөн байна.

Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангийн үндсэн үйл ажиллагааны орлогод нийт 820.5 сая, /сум хөгжүүлэх сангийн орлого 371.7 сая, “Цөм сүргийн үржлийн төв “ОНӨҮГ-ын өөрийн орлого 26.3 сая, ГХБХБГ-ын орлого 13.5 сая, ахмадын хорооны орлого 0.7 сая, аймгийн БТСГ-ын орлого 10.5 сая, Энхтусдэм ӨЭМТ-ийн орлого 358.0 сая, Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ-ын орлого 39.8 сая/, туслах үйл ажиллагааны орлогод нийт 528.5 сая /сум хөгжүүлэх сангийн орлого 14.4 сая, авто замын сан болон АЗДТГ-ын өөрийн орлого 51.7 сая, өрхийн эрүүл мэндийн төвийн орлого 71.6 сая, ахмадын хорооны орлого 4.1 сая, Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ-ын орлого 28.0 сая, ГХБХБГ-ын орлого 302.0 сая, байгууллагуудын ахмадын сангийн орлого 56.7 сая/ төгрөгийг тус тус тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Орлогын данстай холбоотой материаллаг нийт 289.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 139.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 149.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд:

- Залруулсан 139.5 сая төгрөг. Орлогыг ангилал зөрүүтэй бүртгэсэн /Аймгийн ОНӨГ-24.4 сая, Сүмбэр сумын ТТЗ-23.8 сая, ЗДТГ-39.4 сая, ӨЭМТ-25.8 сая, Баянтал сумын 4 дүгээр сургууль 26.1 сая/,*
- Зөвлөмж 149.6 сая төгрөг. Татварын орлогыг орлогын нэр төрлөөр биелүүлээгүй./Сүмбэр сумын ТТЗ -122.3 сая, Баянтал сумын ТТЗ-27.3 сая/*

7.5.11 Зардлын данс

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал 25,418.9 сая төгрөг, өмнөх онтой харьцуулахад үйл ажиллагааны зардал 2,281.5 сая төгрөгөөр өссөн байна.

Зардлын данстай холбоотой нийт 462.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй, зардлыг ангилал зөрүүтэй бүртгэсэн, холбогдох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй хөрөнгө зарцуулсан зөрчлүүд байна.

Аудитын илрүүлэлт:

Зарлагын данстай холбоотой материаллаг нийт 462.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 334.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 66.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 61.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд:

- “Ус-Ду” ОНӨААТҮГ нь зардлыг ангилал зөрүүтэй бүртгэснээс 334.6 сая төгрөгийг залруулсан*
- Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй 66.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн. Үүнд: АИТХ-29.2 сая, АЗДТГ-12.7 сая, Сүмбэр сумын ЗДТГ-24.9 сая*
- Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй төсвийн бүлэгт хооронд шилжүүлж зарцуулсан 61.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн. Үүнд: Ус-Ду ОНӨААТҮГ-26.6 сая, ГБХЗХГ-34,8 сая*

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2021 оны 05, Сүмбэр сумын ИТХ-ын 2021 оны 03, Шивээговь сумын ИТХ-ын 04, Баянтал сумын ИТХ-ын 08 дугаар тогтоолоор тайлант онд 6.641.1 сая төгрөгийн татварын болон татварын бус орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 9,992.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 150.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 13. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого	3,780.0	4,817.5	1,037.5	27.4
Үйл ажиллагааны орлого	82.1	190.0	107.9	131.4
Хөрөнгийн орлого	211.5	279.6	68.1	32.2
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	45.5	223.4	177.9	391.0
Шууд бус орлого	205.2	147.3	-57.9	-28.2
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-174.4	-174.4	0.0	0.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	440.0	536.8	96.8	22.0
Бууны албан татвар	5.0	4.6	-0.4	-7.2
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	120.0	112.1	-7.9	-6.6
Малд ногдуулах албан татвар		83.3	83.3	0.0
Улсын тэмдэгтийн хураамж	141.1	248.7	107.6	76.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	24.0	28.0	4.0	16.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	119.0	143.9	24.9	21.0
Газрын төлбөр	350.0	366.1	16.1	4.6
Дуудлага худалдаа	268.0	1,094.9	826.9	308.5
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.0	5.3	5.3	0.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	400.0	682.7	282.7	70.7
Хүү торгуулийн орлого	564.0	1,152.2	588.2	104.3
Түрээсийн орлого	60.0	50.3	-9.7	-16.1
Нийт дүн	6,641.1	9,992.4	3,351.3	50.5

Тайлант оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 50.5 хувиар давж биелсэн боловч орлогын нэр төрлөөрөө 12 нэр, төрлийн орлого нийт 3.338.5 сая төгрөгөөр давж, 4 орлогын төлөвлөгөө нийт 75.8 сая төгрөгөөр тасарсан, төлөвлөгөөгүй 2 орлого 88.6 сая төгрөгөөр биелсэн байна.

Давсан орлого нь дараах орлогууд байна. Үүнд:

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого 1,037.5 сая
- Үйл ажиллагааны орлого 107.9 сая
- Хөрөнгийн орлого 68.1 сая

- хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 177.9 сая,
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 96.8 сая,
- улсын тэмдэгтийн хураамж 107.6 сая,
- түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 4.0 сая,
- хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 24.9 сая,
- газрын төлбөр 16.1 сая,
- дуудлага худалдааны орлого 826.9 сая,
- ус рашааны нөөц ашигласны төлбөр 282.6 сая,
- хүү, торгуулийн орлого 588.2 сая төгрөгөөр тус тус давсан байна.

Харин тасарсан орлого нь 75.8 сая төгрөгийн дараах орлогууд байна Үүнд:

- шууд бус орлого 57.9 сая
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 7.9
- бууны албан татвар 0.4 сая,
- түрээсийн орлого 9.6 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн төлөвлөлт

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 11,854.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 11,854.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сангийн яам Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 4,982.3 сая төгрөгөөр бууруулж, 6,872.2 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Төсвийн төслөөс аймгийн 13 байгууллагын төсвийг 3,440.2 сая, сумын 10 байгууллагын төсвийг 1,217.4 сая, аймгийн 3 сангийн төсвийг 75.0 сая, 13 тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын тогтмол зардлыг 249.7 сая, нийт 4,982.3 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

УИХ-аар батлагдсан Төсвийн тухай хуулиар орон нутгийн 2021 оны төсвийн нийт зарлагыг 16,924.0 сая төгрөгөөр баталсан. Үүнд:

- Төсвийн суурь зарлагыг 6,872.2 сая
- Тусгай зориулалтын шилжүүлгийн зарлага 8,538.2 сая,
- ОНХС-ийн зарлага 1,513.6 сая

Аймгийн 2021 оны төсвийг аймгийн ИТХТ-ийн 2020.12.04-ний өдрийн 03, Сүмбэр сумын ИТХ-ын 2020.12.17-ны 07, Шивээговь сумын 2020.12.18-ны 09, Баянтал сумын 2020.12.21-ний 10 дугаар тус тус тогтоолоор суурь зарлагыг 7,255.2 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн зарлагыг 8,538.2 сая, Орон нутгийн хөрөнгө оруулалтын зарлагыг 1,188.6 сая, аймаг, сумдын ОНХС-гийн зарлагыг 1,895.4 сая, сумдын СХС-гийн зарлагыг 355.7 сая нийт 19,233.1 сая төгрөгөөр баталсан бөгөөд УИХ-аас баталсан төсвийг 2,309.1 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Төсвийн тодотголоор Аймгийн ИТХТ-ийн 2021.07.23-ний өдрийн 05, Сүмбэр сумын ИТХ-ын 2021.08.13-ны 03, Шивээговь сумын 2021.08.10-ны 04, Баянтал сумын 2021.07.30-ны 08 дугаар тус тус тогтоолоор суурь зарлагыг 357.6 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн зарлагыг 347.7 сая, Орон нутгийн хөрөнгө оруулалтын зарлагыг 755.1 сая, аймаг, сумдын ОНХС-гийн зарлагыг 377.2 сая, сумдын СХС-

гийн зарлагыг 3.3 сая нийт 1,840.9 сая төгрөгөөр нэмж, нийт 21,074.0 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХТ-ийн хурлаар төсөвт өөрчлөлт оруулаагүй байхад сумдын ИТХ-аас тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсвийг 200.5 сая төгрөгөөр нэмж, нийт 21,274.5 сая төгрөгийг баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 21,274.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 17,414.0 сая төгрөгийг урсгал зардалд 3,501.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 359.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 9,039.3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,558.0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 9,807.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 47.1 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 236.0 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 587.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 9,039.3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс 9,807.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,558.0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 21.6 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, урьд оны үлдэгдлээс 587.0 сая, нийт 21,013.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 25.5 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу санхүүжүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 398.0 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс нийт 195.3 сая төгрөгөөр давж биелсэн байна. Үүнд: сумдын СХС орлогын төлөвлөөг 199.9 сая төгрөгөөр илүү төвлөрүүлсэн бол “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ нь өөрийн орлогын төлөвлөгөөг 4.6 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

Туслах үйл ажиллагааны орлого 66.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 33.0 сая төгрөгөөр давж биелсэн байна. Үүнд

Аймгийн Автозамын сангийн орлого 29.6 сая, АЗДТГ-ын архивын орлого 1.5 сая, сумдын СХС-гийн орлого нь 1.9 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 5.8 сая, ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчаас 114.3 сая, дээд шатны төсвийн захирагчаас 644.5 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 287.0 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 214.3 сая, нийт 1,265.9 сая төгрөгийн орлогыг бүртгэж тайлагнасан байна.

Үүнээс цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 64.3 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 25.7 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 2.0 сая, хангамж, бараа материалын зардалд 85.0 сая, нормативт зардалд 107.9 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 85.3 сая, томилот, зочны зардалд 6.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 232.9 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 336.5 сая, бусад урсгал шилжүүлгийн зардалд 114.1 сая, хөрөнгийн зардалд 131.8 сая

нийт 1,192.0 сая төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 33.2 сая, орон нутгийн төсөвт 39.9 сая төгрөгийг тус тус төвлөрүүлж, 0.8 сая төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн дансны 270.0 сая төгрөгийн орлого, байгууллагуудын зардлын давхардсан гүйлгээг устгасан байна.

Аймаг, сумдын нэмэлт төвлөрүүлэлтийн дансны эхний үлдэгдэл 119.4 сая төгрөг байснаас тайланд онд аймаг 31.0 сая, сумд 8.9 сая, нийт 39.9 сая төгрөгийг орлогоор төвлөрүүлж, БТСГ-т 13.1 сая, БОАЖГ-т 1.0 сая, АЗДТГ-т 4.0 сая, Сүмбэр сумын ЗДТГ-т 90.0 сая, нийт 108.1 сая төгрөгийг тус тус олгож, аймаг, сумдын ерөнхий орлогод 11.3 сая төгрөгийг төвлөрүүлж, 39.9 сая төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 147 мэдээллээс 138 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар харьяа 31 байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2,561.2 сая төгрөгийн зөрчил илэрч, 20 байгууллагад 1,703.3 сая төгрөгийн 20 албан шаардлага, 11 байгууллагад 857.9 сая төгрөгийн 11 зөвлөмж өгсөн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 73.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс зөрчлийн давтан гаргахгүй байх 73.3 сая төгрөгийн 8 зөвлөмж, хязгаарлалттай санал дүгнэлт авсан 2 төсвийн захирагчид хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 14 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	8	73.3	7	64.0	1	7.3	87.5
Албан шаардлага	2	0	2	0			100
Нийт	10	73.3	9	64.0	1	7.3	87.5

Хэрэгжээгүй зөвлөмж нь аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд түрээсийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах зөвлөмж өгсөн боловч зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 34 төсвийн байгууллага, 6 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 3 төсвийн төвлөрүүлэн захирагч, 10 тусгайн сангийн, нийт 53 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 37 байгууллагад дүгнэлт гаргаж, 16 байгууллага түүврээр хамрагдсан байна

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт 29, “Хязгаарлалттай” санал дүгнэлт 7 /Сүмбэр сумын 5 дугаар сургууль, 5 дугаар цэцэрлэг, Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч, ЗДТГ, ОНХС, Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг, Эрүүл мэндийн төв/, “сөрөг” саналт дүгнэлт 1 /аймгийн “Цөм сүргийн үржлийн төв” / тус тус өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 7,275.4 сая төгрөгийн 323 алдаа, зөрчил илрүүлснээс 2,624.8 сая төгрөгийн 130 алдааг аудитын явцад залруулж, 29.4 сая төгрөгийн 23 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,915.3 сая төгрөгийн 89 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1,705.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 81 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Өмнөх оны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4,393.2 сая төгрөгийн 451 алдаа, зөрчил илрүүлснээс 3,281.0 сая төгрөгийн 222 алдааг аудитын явцад залруулж, 73.8 сая төгрөгийн 11 алдаа, зөрчлийг залруулаагүй, 73.5 сая төгрөгийн 56 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 653.9 сая төгрөгийн 73 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 311.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 89 зөвлөмж өгсөн байна.

Тайлант оны алдаа, зөрчлийн дүн өмнөх оноос 2,882.2 сая төгрөгөөр буюу 65.6 хувиар өссөн байна.

Өмнөх оноос актын дүн 44.1 сая, залруулгын дүн 656.2 сая, залруулагдаагүй алдаа 73.8 сая төгрөгөөр тус тус буурсан боловч зөвлөмжийн дүн 1,394.9 сая, албан шаардлага 2,261.4 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Тайлант он		Шилэн данстай холбоотой		Зөрүү	
	Тоо	Дүн	Тоо	Дүн			Тоо	Дүн
Залруулга	222	3,281.0	130	2,624.8			-92	-656.2
Залруулаагүй алдаа	11	73.8	0	0.0			-11	-73.8
Төлбөрийн акт	56	73.5	23	29.4			-33	-44.1
Албан шаардлага	73	653.9	89	2,915.3	20	1,703.3	16	2,261.4
Зөвлөмж	89	311.0	81	1,705.9	11	857.9	-8	1,394.9
Нийт	451	4,393.2	323	7,275.4	31	2,561.2	-128	2,882.2

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 75.8 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, шилэн дансанд тавих дотоод хяналтыг сайжруулах 1 зөвлөмж тус тус хүргүүллээ.

4.1.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй

4.2.2 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт тогтоогдоогүй

4.2.3. Албан шаардлага

1. Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ биелсэн боловч 3 нэр төрлийн татварын орлого 66.2 сая төгрөгөөр тасарсан, хуулиар тогтоосон татварын орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 14.3-т “төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба Эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна

Шийдвэрлэсэн нь : Батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах албан шаардлага өглөө.

4.2.4 Зөвлөмж

1. Шилэн тухай дансны хэрэгжилттэй холбоотой

1.1 Илрүүлэлт:

ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар харьяа 31 байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2,561.2 сая төгрөгийн зөрчил илэрч, 20 байгууллагад 1,703.3 сая төгрөгийн 20 албан шаардлага, 11 байгууллагад 857.9 сая төгрөгийн 11 зөвлөмж өгсөн байна. ТЕЗ-ийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд сар бүр хяналт тавин ажиллаж байгаа боловч жил бүр зөрчлийн дүн буурахгүй, үр дүн хангалтгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий дотоод хяналтын нэгжийг үр дүнтэй ажиллуулах, зөрчлийг бууруулах ажлыг зохион байгуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт					Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
			Үүнээс							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таггалзах	Түүвэрт хамруулсан	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо
1	Аймгийн Засаг дарга	ГСА-2022/01/СТА-ТЭЗ		1				3	75.8					2	75.8			1	
ДҮН				1				3	75.8					2	75.8			1	